



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 13/03

Эрдэнэт

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа зарим барилгыг дуудлагын худалдаагаар худалдах жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Ээлжит XIII хуралдааны 13/03 дугаар тогтоолын хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Газрын хэмжээ м2	Хөрөнгийн балансын үнэ	Элэгдлийн дүн	Үлдэх өртөг	Дуудлагын худалдааны доод үнэ
1	Эрдэнэ багийн байр	Эрдэнэ баг, Гал унтраах, аврах 68 дугаар ангийн зүүн талд	2008.10.10	957	47,720,240	5,567,361.24	42,152,875.76	70,205,930
2	Замын цагдаагийн постын байр	Булган аймаг явах зам /Булган аймаг, Орхон сум/	2009.06.30		20,390,243	2,270,929.68	18,119,425.4	13,957,521
3	Хашаа, байшин	Баянбулаг баг, Баян-Өндөр 25 дугаар гудамж, 61 "б" тоот	2016.05.10	700	25,000,000		25,000,000.00	31,037,710
НИЙТ ДҮН					93,110,483	7,838,290.92	85,272,192.08	